

Хавсралт хүснэгт 3.6

				“Нүүдлийн эмнэлгийн баг” 6 аймгийн, 28 сум, Улаанбаатар хотын алсдагдсан 2 дүүрэгт урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулан нийт 6,806 хүн хамрагдаж үүнээс 51,283 лабораторийн шинжилгээ, 31,248 багажийн шинжилгээг тус тус хийгдсэн байна. Үүнээс төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгээр зүрх судасны өвчлөл 40.6 хувь, ерөнхий эмчийн үзлэг 51.5 хувь, эмзэгтэйчүүдийн эмчийн үзлэгээр 29.9 хувь нь өвчлөлттэй байна. Эрт илрүүлгийн хугацаанд хавдрын нийт 53 шинэ тохиолдлыг илрүүлснээс ходоодны хавдар 5, элэгний хавдрын 6 тохиолдолд мэс заслын тусламж үйлчилгээнд оруулж амжилттай эмчилсэн.
				• Амилуулах суурь тусламжийн сургалтыг 5 удаа зохион байгуулж, 250 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. • Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг тогтмол явуулж тайланд онд 2 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 250 албан хаагч хамрагдсан байна. • Хууль сахиулах байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэг Эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тухай ойлголт сэдвээр бодит кейс дээр тулгуурлан 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 200 эмч мэргэжилтнүүд хамрагдсан. • Ажил олгогч, удирдах ажилтанд зориулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н сургалтад нийт 6 удаагийн 29 эмч эмнэлгийн ажилтан хамрагдаж батламж гардан авсан. • Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт; /цаашид “Эрсдэлтэй ажлын байрны сургалт” 5 удаа сургалтад нийт 10 ажилтан хамрагдуулж нэг жилийн хугацаатай үнэмлэхжүүлсэн. • Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практикт дадал олж авахад чиглэсэн агууллагыг багтаасан нийт 12 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 620 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан.
	Бусад	23	44 /2754 хүн/	

Хавсралт хүснэгт 3.6

					- Гамшгийн үеийн бэлэн байдал (галын болон газар хөдлөлт)-ын сургалтыг 2 удаа зохион байгуулж, давхцсан тоогоор 670 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. - Улаан бурухан халдварт өвчний тохиолдол манай улсад бүртгэгдсний дагуу тухайн халдварт өвчний талаарх мэдлэг сэргээх сургалтын хувиар гарган, халдварын сэжигтэй, халууралт, тууралттай тохиолдлыг тусгаарлан яаралтай мэдээлэх, хамар заглиур, ам-залгиур, цусны сорьц авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лабораторид хүргүүлэх сургалтыг 5 удаагийн 120 гаруй эмч нарыг сургалтанд хамруулсан. - Томуу, томуу төст өвчний дэгдэлт хариу авах арга хэмжээний сургалтыг нийт 1 удаа зохион байгуулан 178 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100% хамрагдсан. - Тус эмнэлгийн холбогдох хууль, дүрэм, журмыг таниулах мэдлэг олгох зорилгоор шинээр ажилд орж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг 4 удаа 407 шинээр ажилд орж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан.
	1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: (давхардсан тоогоор)	100% 19475	100% 14786	
Үүнээс		Эмэгтэй албан хаагч	85,6%	87%	2024 онд байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд 139 сургалт зохион байгуулан давхардсан тоогоор нийт 14,786 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчийг 100 хувь хамруулсан. Үүнээс 87% нь эмэгтэй, 13% эрэгтэй албан хаагч сургалтанд хамруулсан байна.
		Эрэгтэй албан хаагч	14,4%	13%	
		Удирдах албан тушаалтан	13%	13%	
		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	87%	87%	
	1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	100%	100%	2024 онд нийт 139 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдвал зохих албан хаагчдыг 100% хамруулсан.

Хавсралт хүснэгт 3.6

2.2	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	97	95	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаадын зочин профессорын багуудтай хамтарсан ажлын байрны мэс засал сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 11 улсын 13 байгууллагын 6 чиглэлийн зочин профессорын багийн 57 мэргэжилтэнг хүлээн авч хамтарсан эмнэлзүйн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Хамтарсан багаар Монгол улсад хараахан бие даан хийх боломжгүй нарийн төвөгтэй, өндөр ур чадвар шаардсан нийт 242 мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлснээс, насанд хүрсэн 159, хүүхдийн 83 тохиолдолд мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлсэн. Гадаад зочин профессорын багтай хамтарсан мэс заслын тоо өмнөх оны мөн үеиэс 3 дахин нэмэгдсэн. Гадаад багтай хамтарсан мэс заслын тусламжаар нийт 3,188,222,340 төгрөгийн өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээг эх орондоо эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийж гүйцэтгэн, эрүүл мэндийн эдийн засгийн гадаад руу чиглэсэн урсгалыг бууруулж ажилласан. Зочин профессорын багтай хамтарсан эмнэлзүйн үйл ажиллагаагаар Эрүүл мэндийн сайдын А/273 дугаар тушаалын жагсаалтын А1,2, В6-10 дугаарт багтсан нийт 6 төрлийн бүлэг өвчний оношилгоо эмчилгээний технологийг нутагшуулах чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнээ чадавхижуулж ажилласан. 2024 оны байдлаар 12 улсад 54 эмч, 28 сувилагч, 5 эмнэлгийн мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдсан байна. Гадаад сургалтад 25 эмч эмнэлгийн мэсгэжилтэн урт хугацааны, 62 богино хугацааны сургалтад хамрагдан мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. 2023 онд 79 мэргэжилтэн хамрагдсан бол 2024 онд 87 мэргэжилтэн хамрагдаж, нийт 5.06%-иар өссөн байна.Үүнд: • Төрийн сангийн зардлаар 7; • Гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн хүрээнд 61 ; • Бусад нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагын дэмжлэгээр болон хувийн зардлаар 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдсан. MON007 (Монгол Улс дахь зурх судлал, зүрхний мэс засал ба телемедицин) төслийн хүрээнд WEBINAR сургалтанд 2 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.
	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: (давхардсан тоогоор)	81	83	
	Эмэгтэй албан хаагч	57	63	
	Эрэгтэй албан хаагч	24	24	
	Удирдах албан тушаалтан	13	20	
Үүнэ эс	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	68	67	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	11,4%	11,9%	

Хавсралт хүснэгт 3.6

3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	401 сая төгрөг	806 сая төгрөг	2024 онд албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нийт 806,954,721₮ төгрөг зарцуулсан байна. Үүнд: • Дотоод сургалтанд: 20,000,000₮, • Гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт 104,941,594 ₮-ийн цалин • Төсөл, хөтөлбөрийн зардлаас гадаад сургалтад 641,942,261.67₮ • Улсын төсвийн санхүүжилтээр: 40,070,866₮ 2024 онд шилжилт хөдөлгөөн 12.2 хувь буюу ажлаас гарсан 98, ажилд шинээр орсон 156 ажилтан байна. Оны эцсийн гүйцэтгэл 98,5% буюу 798 ажилтан ажиллаж байна. Шилжилт хөдөлгөөнийг өмнөх онтой харьцуулахад 7,8% хувиар буурсан үзүүлэлттэй байна.
	3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15%-аас доош	12,2%		
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	34,9%	30,1%	• Засгийн газрын 2024 оны 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор эрүүл мэндийн ажилтны үндсэн цалин 10%, нийтлэг үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалинг 20% тус тус нэмэгдүүлсэн. • Эмнэлгийн захирлын 2024 оны А/86 дугаар тушаалаар эрүүл мэндийн ажилтны үндсэн цалингийн дунджийг 1,544,471 төгрөг, нийтлэг үйлчилгээний ажилтны үндсэн цалингийн дунджийг 1,349,353 төгрөг болгож нэмэгдүүлсэн. • Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 07 дугаар тогтоолоор цалин хөлс, шагнал, урамшууллын зардлыг 27,6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 8,7 хувиар нэмэгдүүлсэн. • 2024 оны байгууллагын нийт төсөвт цалин, хөлс, шагнал, урамшууллын зардал төсвийн 30,1 хувийг эзэлж байна. • 2024 онд хоол унааны нөхөн олговрын хэмжээг нэг дахин нэмэгдүүлж хонот 10,000 төгрөг байхаар төсвийн тооцоолол хийж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 07 дугаар тогтоолоор нийт зардал 2,085,600.0 төгрөгийг баталсан. • Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын сэтгэл ханамжид тулгуурлан тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгоход нотолгоогоор
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян, төг)	5,000	10,000	
5	Албан хаагчдын ажлын байрны	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал	98,5%		

Хавсралт хүснэгт 3.6

хэвийн нөхцлийг бүрдүүлэх	асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)			хангах, хариу арга хэмжээ авч төлөвлөх зорилгоор тус эмнэлгийн эмч, ажилчдын 74,4% хувь буюу 566 ажилтан судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан эмнэлгийн эмч, ажилчдын 98,5% нь зөрэг сайн сэтгэл ханамжтай байсан. • Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, ажилчдын ажлын байрны сэтгэл ханамжийн нэмэгдүүлэх, ажилчдын болон үйлчлүүлэгчдийг тав тухтай орчин нөхцөлд тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэн ажиллаж, 6 тасаг нэгжид засвар тохижилтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн 846,186,298 төгрөг зарцуулсан. • Эмч, ажилчдыг стандартад нийцсэн, шаардлага хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр үе шаттайгаар хангах төлөвлөлт хийж, 12 төрлийн 1132 ширхэг 94,876,300 төгрөгийг өртөг бүхий ажлын хувцасны хангалт хийсэн.
6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд)	878 1-2 удаа	1606 7 удаа	2024 онд тус эмнэлэгт 133 эмч, эмнэлгийн мэргэжилтний хэвтэн эмчлүүлснээс сэргээн засах, уламжлалтын өдрийн эмчилгээнд 41 нь хамрагдаж, өдрөөр эмчилгээ хийлгэсэн. Давхардсан тоогоор 1,606 эмч, ажилтан эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдсан байна. 1. 2024 онд эмч, эмнэлгийн ажилчдын 439 нь 2 дахь удаагийн, шинээр ажилд орсон 87 ажилтан анх удаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан. 2. Эмч мэргэжилтний хавдрын эрт илрүүлэгт 334 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 3. ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмч нар үзлэг, оношилгоо хийж, давхардсан тоогоор нийт 264 эмэгтэй сувилагч нарт үзлэг, оношилгоо хийсэн. 4. Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгт 212 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд хамрагдсан байна. (тархины харвалтаас сэргийлэх, эрсдэл тодорхойлох мэдрэлийн эмчийн үзлэгт 50, Уушгины эмчийн үзлэгт 28, чих, хамаар, хоолойн үзлэгт 95, Бөөрний урьдчилсан сэргийлэх үзлэгт 39). 5. Элэгний В, С вирус тээгч, элэгний архаг үрэвсэл, хатууралтай 120 ажилтанд жил бүр элэгний үйл ажиллагааны шинжилгээ, элэгний хавдрын маркер, хэвлийн хэт авиан оношилгоог хийж, элэгний эмчийн байнгын хяналтанд эмчилгээг хийж байна. 53 ажилтанд элэгний вирусийн эсрэг вакцины 1,2,3-р тунд хамруулж, эрсдлээс сэргийлсэн.

Хавсралт хүснэгт 3.6

					6. 40-өөс дээш насны нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бүдүүн гэдэсний дурангийн оношилгоонд хамруулснаас 3 тохиолдолд өмөн, 5 тохиолдолд полип илэрч мэс засал эмчилгээ хийлгэж эрүүлжүүлсэн. 7. "Ясны сийрэгжилттэй тэмцэх дэлхийн өдөр"-өөр 120 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд денситометрын аппаратаар ясны бүтцийг үзэхэд 73.4% нь эрүүл, 26.6% нь ясны сийрэгжилттэй болон бүтцийн өөрчлөлтэй гарсан. 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд үений тэжээлийн бэлдмэлийг үнэгүй өгсөн. Эмч, ажилтны эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч 800 ажилтанд 11 сая төгрөгийн өртөг бүхий тархины цусан хангамж сайжруулах "Пирацезин эмий" тарааж, дархлаа дэмжих витамин D, витамин C олгосон.
	6.2	Албан хаагчдын хамрагдалт	100%	100%	
7.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая төг)	1 тэрбум 46 сая төгрөг	1 тэрбум 446 сая төгрөг
2024 онд ажигчдын нийгмийн асуудал, нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулалд нийт 1,446,479,523 төгрөг зарцуулсан. - Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 33 эмч, ажилтанд 872,395,065 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон. Хөдөлмөрийн дотоод журамд заасан тэтгэмж, шагнал урамшуулалд 574,669,860 төгрөгийг олгосон байна. - Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг өсгөх, цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн олгосон. Засгийн газрын 2024 оны 128 тогтоолоор баталсан доод жишгээс эрүүл мэндийн ажилтны цалин 27 хувиар, нийтлэг үйлчилгээний ажилтны цалин 14 хувиар нэмэгдсэн байна. 2024 онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1-25 хувиар тооцож, нийт 808 хүнд нэмэгдэл олгож байна. - Хөдөлмөрийн хүнд нөхцөлийн нэмэгдлийг 440, хортой нөхцөлийн нэмэгдлийг 21, Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг 22, нийт 483 ажилтанд олгож байна.					

					• 2024 онд нийт 291 ажилтнаас чөлөө авах хүсэлт ирүүлснээс 86 нь цалингүй, 203 цалин (СҮЦ-60%)-тай чөлөө авсан байна. Шинэ хүүхэдтэй болсон 2 (аав) ажилтанд хөдөлмөрийн хууль, дотоод журамд заасны дагуу ажлын 10 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосон. • Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 2024 оны эхний 3 улиралд давхардсан тоогоор 2,206 албан хаагчид ажлын үр дүнг үндэслэн 1,548,992,251 төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон. • Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадвараа түр алдсан 125 эмч, эмнэлгийн ажилтанд 57,309,645 төгрөгийн тэтгэмжийг тооцож олгосон, • Шинэ хүүхэдтэй болсон 2 ажилтанд хөдөлмөрийн хууль, дотоод журамд заасны дагуу аавын чөлөө ажлын 10 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосон. • Монгол улсын төрийн дээд одон медаль болон салбарын шагналд нийт 129 ажилтныг тодорхойлж, Ерөнхийлөгчийн зарлигаар 44 эмч, эмнэлгийн ажилтан төрийн одон медалиар, 60 эмч, эмнэлгийн ажилтан эрүүл мэндийн салбарын шагналаар шагнагдсан, дагалдах мөнгөн урамшуулалд 3,480,000 төгрөг зарцуулсан байна. • Эмч, ажилчдыг стандартад нийцсэн, шаардлага хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр үе шаттайгаар хангах, төлөвлөлтийн гүйцэтгэлд хяналт тавих, чанаржуулах чиглэлд 12 төрлийн 1132 ширхэг 94,876,300 төгрөгийг зарцуулсан байна. • Эмнэлгийн түүхт 70 жилийн ойг угтан төв, алба, тасаг, нэгжүүд ажиллах орчноо сайжруулах бүтээлч ажлуудыг санаачлан зохион байгуулж, нийт 267 төрлийн 531,978,625 төгрөгийн ажлыг хувь хүн, байгууллагын хөрөнгө оруулалт, эмч ажилчдын санал санаачилга дотоод нөөц болголцоогоо ашиглан хийж гүйцэтгэсэн. • Эмч ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спорт, дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн гадна талбайд 22.8 сая төгрөгийн өртөг бүхий сагсан бөмбөгийн 3х3 талбайг шинээр байгуулсан.
--	--	--	--	--	--

				• Эмч ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Уулын алхалтын” групп, Иогийн групп, Бүжгийн группуудыг нээж, 60 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт уриалж, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. • 06-р сарын 23-ны өдөр уулын явган аялал зохион байгуулж, 50 ажилтан оролцсон. • Эмнэлгийн ажилтны хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж, 0-10 настай 100 хүүхдэд зүрхний эмчийн үзлэг, оношилгоонд хамруулсан. Үүнээс 10 хүүхдэд зүрхний өвчин оношлогдож шаардлагатай оношилгоо шинжилгээ хийгдэж зүрхний эмчийн хяналтанд оруулсан.
--	--	--	--	--

ХЯНАСАН: ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ, АУ-НЫ ДОКТОР

Ц.ТӨМӨР-ОЧИР

НЭГТГЭСЭН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА

Б.АЛЫГРИМАА

